

---

Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт  
байрлах “Сорилтын шинжилгээний  
лаборатори” төслийн 2023 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---

Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 5723612

Хянасан:

Нийслэлийн байгаль орчны газрын ХБОБНХ-ийн мэргэжилтэн

Хэрэгжилтийг гаргасан:


“Эхмонголын байгаль” ХХК-ийн гүйцэтгэх захирал



Б. Сайнзаяа

Хянасан:

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн гүйцэтгэх захирал



М. Ганчимэг

Улаанбаатар хот  
2023 он

## Агуулга

1.1. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ .....	3
1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ .....	7
1.3. ХОГ ХАЯГДАЛ .....	8
4. ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	14
5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	17
6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	17
7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	20
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	24

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Сорилтын шинжилгээний лаборатори
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011420015
Хаяг:	Регистрийн дугаар: 5723612 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 хороо, үйлдвэр, 100/1 Утас: 99110734

“Ар Си Инспекшн” групп нь 2006 онд Голланд улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд ISO 9001:2008 стандартаар итгэмжлэгдсэн, хатуу бүтээгдэхүүн, металл, далайн хяналттай холбоотой үйл ажиллагаа явуулдаг хараат бус, хувийн өмчит, хөндлөнгийн хяналтын компани юм. “Ар Си Инспекшн” групп нь дээж бэлтгэл болон сорилт туршилтын ажлаараа London metall exchange /LME/-д бүртгэгдсэн цөөн Олон Улсын Хөндлөнгийн Хяналтын компаниудын нэг бөгөөд 40 гаруй улс орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг юм байна. Тус группийн Монгол улс дахь салбар “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон эрдэс, металлын лаборатори болон хөндлөнгийн хяналтын лабораторийг 2013 онд байгуулсан. “Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК-ийн хөндлөнгийн хянагчид болон химичид нь эрдэс, металлын, тэр дундаа баяжмал, нүүрс, коксжсон материал болон түүн дотроос уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн болон Оюу-толгойн зэс, молибдений баяжмалын хяналтыг гүйцэтгэж байсан арвин туршлагатай хамт олноос бүрджээ.

“Ар Си Инспекшн Азия Ассайрс” ХХК нь доорх стандартуудаар итгэмжлэгдсэн:

- MNAS/ISO 17025:2007
- MNAS/ISO 17020:2013
- MNAS/ISO 17025:2018

Эрдсийн лаборатори нь 2016 оны 4 сард APLAC (Ази Номхон Далайн орнуудын Лаборатори Итгэмжлэлийн Холбоо)-аар магадлан итгэмжлэгдсэн бөгөөд MRA болон ILAC-ын хавсарсан лого тэмдгийг сорилт туршилтын үйлчилгээндээ ашиглах эрхийг авсан байна.

### 1.1. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Эрдэс, металлын лаборатори нь олон улсын хяналтыг гүйцэтгэж байсан 5-30 жилийн туршлагатай инженерүүдийн багийг бүрдүүлж, нийт 17 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Сорилтын шинжилгээний лаборатори нь мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэгдсэн туршлагатай боловсон хүчин, Америк, Европын улсуудад үйлдвэрлэгдсэн лабораторийн дэлхийд тэргүүлэгч орчин үеийн технологи, олон улсын стандартын дагуух үйл ажиллагаагаараа дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх найдвартай үр дүнг гарган ажилладаг.


Эрдэс, төмөрлөгийн бус хүдэр, баяжмал, газрын ховор, өнгөт, үнэт, өндөр цэвэршилттэй металлуудын гэх мэт өргөн хүрээний үйлчилгээ үзүүлж байна. Салбар лабораториуд руу дээжийг илгээж шинжилснээр борлуулагч болон худалдан авагчдад найдвартай дүнг өгдөг ба үүнийг үндэслэн шинжилгээг гүйцэтгэх хугацааг тооцоолсон байдаг.

**Хүснэгт 1. Үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хийц /загвар/	Ашиглалтанд оруулсан огноо	Хэмжих хязгаар, нарийвчлал
1	Атом Шингээлтийн Спектрометр	PinAAcle 500	2018.06	185-900нм
2	Атом Шингээлтийн Спектрометр	AA-200	2014.09	185-900нм
3	Спектрофотометр	AE-S80-2S	2015.02	190-1100nm
4	Аналитик жин	Mettler-Toledo AG204	2014.05	max=210g, min=10mg, d=1mg
5	Аналитик жин	CAS Corporation, GAUY - 120	2019.05	max=210g, min=10mg, d=1mg
6	Микро аналитик жин	Mettler-Toledo MX5-029	2014.05	max=5.1g, d=1µg
7	Хагас микро аналитик жин	Mettler-Toledo AE260	2014.05	max=205g, min=50mg, d=1mg, e=1mg
8	Техник жин	CAS Corporation, CBL-3200H	2017.10	max=3200, min=0.01g
9	Шатаах зуух	TC2044	2014.05	1100°C хүртэл
10	Шатаах зуух	TC2044	2014.05	1100°C хүртэл
11	Хатаах шүүгээ	UM500	2014.05	20-220°C хүртэл
12	pH метр	edge® Dedicated pH Meter	2017.07	1-16 ±0.1pH
13	Ионметр	Ion meter-930	2015.02	0.00-20.00mg/L
14	Ус нэрэгч аппарат	Master-S	2015.01	1.0-4.0Kg/cm <sup>2</sup> , 120W, 220V, 50Hz
15	Усан ванн	DK-98-I	2015.01	5-100C
16	Компрессор	5KC37SN363ZX	2014.10	220-240V, 50-60Hz, 2,2A
17	Цахилгаан халаагуур	CERAN 500	2014.05	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
18	Цахилгаан халаагуур	CERAN 500	2014.05	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
19	Цахилгаан халаагуур	CERAN 500	2014.05	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
20	Цахилгаан халаагуур	CERAN 500	2014.05	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
21	Цахилгаан халаагуур	CERAN 501	2017.01	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
22	Цахилгаан халаагуур	CERAN 502	2017.01	50-500°C, 3000W, 230Volt, 50-60Hz
23	Индукцийн холбоостой плазмын спектрометр	Termo iCAP-7200	2017.06	20-32A, 4000W, 200-240Volt, 50-60Hz
24	Хайлуулалтын зуух	Biobase MF24-14T	2017.01	1400°C хүртэл
25	Хайлуулалтын зуух	Biobase MF24-14T	2017.01	1400°C хүртэл
26	Купеляцын зуух	Biobase M6-12T	2017.01	1200°C хүртэл
27	Техник жин	CBX 12KH	2017.01	max=12kg, min=1g, d=0.1g
28	Цахилгаан баригч UPS	France	2019.04	20kVA, 220/380V, 50Hz
29	Ультра соник цэвэрлэгч	WUC-D06H	2019.04	230V, 425W, 50-60Hz,
30	Соронзон хутгуур	MSH-20D	2019.04	230V, 660W, 50-60Hz,
31	Сэгсрэгч		2019.09	



Зураг 1. Шатаах зуух ба татах шүүгээ



Зураг 2. Хатаах зуух ба атом шингээлтийн спектрометр



Зураг 3. ISO Lab сертификат бүхий шил сав болон спектрофотометр

**Химийн бодис:** “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн сорилтын шинжилгээний лабораторийн агуулахад нь нийт 69 төрлийн 1.955 тонн химийн бодисыг хадгалж байх бөгөөд эдгээрээс шингэн бодис 10, хатуу байдалтай 59 бодис байна. Шинж чанарын хувьд авч үзвэл эрдэс болон органик хүчил 11, суурь шүлт 3, хүчлийн давс 32, металлын оксид 6, органик бодис 11, стандарт үүсмэл 1, индикатор буюу илрүүлэгч 5 төрлийн бодисууд байна.

Тус компани нь агуулахын 1 өрөөтэй бөгөөд нийт 22 м<sup>2</sup> талбайтай агуулахыг түрээслэн ашиглаж байна. Тус химийн бодисын агуулахад 2020.03.26-нд Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын ажил гүйцэтгэж “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MNS 6458:2014-ийн шаардлагыг хангаж байна хэмээн

дүгнэлт гаргасан байна. Уг хяналт шалгалтаар тус агуулахыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Лабораторид ашиглах химийн бодисыг хадгалах өрөө нь 22 м<sup>2</sup> талбайтай, стандартад заагдсаны дагуу тохижуулан, зориулалтын химийн бодис хадгалах аюулгүй байдлыг хангасан 4 ширхэг кабин, ацетилен, аргон хий хадгалах өрөөнд 2 ширхэг аюулгүй байдлын кабин тус тус байрлуулсан, механик агааржуулалтын систем болон хяналтын камер суурилуулсан 24 цагийн харуул хамгаалалттай.
- ✓ Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ MNS 5029:2011 стандартыг хангасан.
- ✓ Агуулахын байранд хийсэн физик хэмжилтээр гэрэлтүүлэг 250 люкс байна.
- ✓ Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээс олгосон №033/06 тоот галын аюулгүй байдлын дүгнэлттэй.
- ✓ Ажилтанд химийн бодистой харилцан ажиллах үеийн аюулгүй ажиллагааны хамгаалах хувцас, химийн бодис асгарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний иж бүрдэл зэргийг олгож, болзошгүй ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

Агуулахын ерөнхий байдлыг зураг 4-д үзүүлэв.



Зураг 4. Химийн бодисын агуулах

## 1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Төслийн талбай нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, тус дүүргийн Засаг даргын 2017 оны 10 сарын 05-ны өдрийн А/756 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 178019/0055 дугаар бүхий 384м<sup>2</sup> газрыг контор, үйлдвэрлэл зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшихээр эрх авсан иргэн Ц. Бадмаанямбууд олгогдсон газар байна. Иргэн Ц. Бадмаанямбуугийн эзэмшил газарт баригдсан 4 давхар барилгад түүний “Өсөх түрүү” ХХК конторын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэхээс гадна “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК “Сорилтын шинжилгээний лаборатори”-ийн зориулалтаар 3-4 давхрыг өмчлөгч иргэнтэй түрээсийн гэрээ байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 2. Талбайн эргэлтийн цэг

№	Өргөрөг			Уртраг		
1	47	54	4.34	106	52	10.25
2	47	54	4.56	106	52	10.11
3	47	54	4.52	106	52	9.99
4	47	54	4.89	106	52	9.73
5	47	54	4.97	106	52	9.98
6	47	54	5.18	106	52	10.63
7	47	54	4.58	106	52	11



Зураг 5. Төслийн талбайн байрлал

### 1.3. ХОГ ХАЯГДАЛ

#### Хатуу хог хаягдал

**Ахуйн:** Лабораторийн ажиллагсдын ахуйн хатуу хог хаягдал гарахаар байна. Хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгж буюу Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан зайлуулж байна.

**Лабораторийн:** Уг лабораторийн хатуу хог хаягдлын эх үүсвэр нь агуулахад хадгалж буй химийн бодисын сав баглаа боодлоос гарах хог хаягдал байна.

Харин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний явцад ашиглалтаас бүрмөсөн гарсан сэлбэг хэрэгсэл зэрэг зүйлс гарч болох юм. Тэдгээрийг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд тушаах, дахин ашиглах зэрэг арга хэмжээ авна.

Төслийн ажиллах хүчин чадлыг үндэслэн Засгийн газрын 2017 оны 12-р сарын 25-ны өдрийн А/368-р тушаалын хавсралт “**ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛ**”-ын дагуу тооцвол хоногт дунджаар 25.5 кг, сард 765 кг, жилд 9.18 тн орчим хог гарахаар байна.

Иймд ахуйн гаралтай, дахин ашиглах боломжтой хатуу хог хаягдлыг ангилж ялгасан, шаардлага хангасан хогийн цэгт төвлөрүүлэн зохих журмын дагуу зайлуулж хэвшсэн байна.

#### Шингэн хаягдал

**Төслийн ус хэрэглээ:** Усны нийт хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 сарын 3-ны өдрийн А/301-р тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцож хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Шаардлагатай усны хэмжээ

№	Ус хэрэглээний төрөл	Тоо хэмжээ, хүн/хон	Норм,	Хоногийн хэрэглээ, л	Сарын хэрэглээ, м <sup>3</sup>	Жилийн хэрэглээ, м <sup>3</sup>
1	Ажилтан	17	80 л/хон	1360	40.8	489.6
2	Лаборатори	17	300 л/ажилтан	5100	153	1836
Нийт				6460	193.8	2325.6

Энэхүү тооцооноос харахад төслийн үйл ажиллагаанд нийтдээ жилд **2325.6м<sup>3</sup>** ус шаардлагатай байна.

Төслөөс лабораторийн шинжилгээнээс гарах бохир ус болон ахуйн гаралтай шингэн хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны үед хоногт дунджаар 6.46м<sup>3</sup>, жилд 2325.6 м<sup>3</sup> бохир ус гарахаар байна. УСУГ-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан гэрээг хавсаргав.



## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн “Сорилтын шинжилгээний лаборатори” төслийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг тухай бүрд нь хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь илүү болох юм.

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг) химийн нэмэлт бодисууд болон лабораторийн шинжилгээнд ашигласан усыг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага.” MNS656:2015 стандартад хүргэн нийлүүлээгүйгээс гадаргын болон газрын доорх ус бохирдох, болгоомжгүй байдлаас гал түймэр гарах зэрэг асуудал байна.

Төслийн агаарын бохирдлын гол эх үүсвэр нь лабораторийн шинжилгээний үйл явцаас үүсэх хийнүүд болон ажилчдын автомашинуудын хөдөлгөөний үед үүсэх тоосжилт болон хийн бохирдол байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг нэгтгэн доорх хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 4. Байгаль орчны болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэгтгэл**

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөл-лийн зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>							
Газарт үзүүлэх нөлөөлөл	0	0	0	0	0	-	
Агаарт үзүүлэх нөлөөлөл	-4	-4	-1	-5	-14	56%	M
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл	-5	-3	-1	-2	-11	44%	M
Хөрс, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл	-1	-3	-3	-2	-9	36%	M
Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл	0	0	0	0	0	-	
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	0	0	0	0	0	-	
<b>Дундаж</b>						<b>-45.3%</b>	<b>M</b>
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>							
Газрын гадаргын нөөц баялаг	0	0	0	0	0	-	
Бэлчээр, тэжээлийн байдал	0	0	0	0	0	-	
Эрдэс түүхий эдийн нөөц	0	0	0	0	0	-	
<b>Дундаж</b>						<b>-</b>	
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>							
Газрын доорх усны нөөц, чанар	-4	-3	-2	-3	-12	-48%	M
Хөрсний бохирдол	-4	-5	-1	-2	-12	-48%	M
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	0	0	0	0	0	-	
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	0	0	0	0	0	-	
Уул уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх	+6	+5	+1	+3	+14	+56%	+
<b>Дундаж</b>						<b>-48%</b>	<b>M</b>
<b>4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл</b>							
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	0	0	0	0	0	-	

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөл-лийн зэрэг
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	0	0	0	0	0	-	
Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт	0	0	0	0	0	-	
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0	0	0	0	0	-	
Археологи, палеонтологийн олдворт	0	0	0	0	0	-	
<b>Дундаж</b>						-	
<b>5. Бусад нөлөөлөл</b>							
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга	-6	-1	-2	-2	-11	-44%	М
Осол аваар, халдварт өвчин гарах	-6	-1	-3	-2	-12	-48%	М
<b>Дундаж</b>						<b>-46%</b>	<b>М</b>
<b>Үр дүн /ерөнхий дундаж/</b>						<b>-46%</b>	<b>М</b>

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээг нэгтгэн үзвэл - 46.4% хувь буюу дунд зэргийн нөлөөлөлтэй байна. Энэхүү төсөл цаашид БОМТ-г боловсруулан болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтээр харууллаа.

**Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**


№	Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлсэн	Тайлбар
1	Агааржуулалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг байнга анхаарч, засвар үйлчилгээг хийсэн	2023 он	400.0	“Ар Си инспекшн Азиа Ассайрс” ХХК	Авто машинаас гарах бохирдуулагч хийг багасгасан
2	Лабораторийн шинжилгээнээс гарсан химийн бодисоор бохирдсон усыг саармагжуулан аюултай хог хаягдал цуглуулах, тэвэрлэх, дахин боловсруулах, устгах зөвшөөрөл бүхий “Түмэн эгшиг” ХХК-д гэрээгээр нийлүүлж байна.	2023 он	500.0	“Түмэн эгшиг” ХХК	-
3	Лабораторийн шингэн хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хадгалалтад тогтмол хяналт тавьсан. Асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэж бэлэн байлгаж байна.	2023 он	-	-	Химийн бодисын хог хаягдал болон сав баглаа боодлоос үүсэх эрсдэлийг арилгасан.
4	Бодис их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажилласан. Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах бэлтгэлийг хангасан. Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгасан.	2023 он	-	-	Химийн бодисын ашиглалтаас үүсэх эрсдэлийг бууруулсан.
5	Ахуйн хог хаягдлыг ангилан хадгалах, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж байсан.	2023 он	-	ХУД-ийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	Ахуйн хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлсэн.
6	Агаар, хөрсний чанарын мониторинг хийлгэсэн	2023.06 2023.09	258	ЦУОШГ-ын БОХЗТЛ “НАРТ ШУУН” ХХК	Шинжилгээний дүнг хавсаргасан.
	<b>Дүн</b>		<b>1,158.0</b>		



Зураг 6. Агааржуулалтын системийн хяналт



Зураг 8. Шинжилгээнээс гарсан химийн бодисоор бохирдсон хольцыг болон сав баглаа боодлыг хадгалах агуулах



Зураг 9. Шаардлагатай утасны жагсаалт болон агуулах дахь галын булан



Зураг 10. Хуурай бодисын тавиур хадгалж буй бодисууд



Зураг 11. Агуулах дахь химийн бодисын хор аюулын зэрэглэлийн самбар болон хор аюулын ангиллын дагуу шингэн бодис хадгалсан байдал



Зураг 12. Ахуйн хог хаягдлын цэг /ангиан ялгадаг/

#### 4. ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай байгууллагаас 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хийж гүйцэтгэхээр тусгасны дагуу Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Айцын амны” Б хэсгийн тариалалтын талбайд 300 ширхэг хайлаас модыг 2023 оны 10 дугаар сарын 28-ний өдөр тарьж суулгалаа. Мод тарихдаа Хан-Уул дүүргийн мэргэжилтэн Баатарсүрэнтэй холбогдож зааварчилгаа авсан ба 300 ширхэг хайлаас модыг 60 нүхэнд 5 ширхгээр багцалж тарих зааварчилгаа өгсний дагуу Хан-Уул дүүргийн Тохижилт нийтийн үйлчилгээний хэлтсийн талбайн мастер Бат-Эрдэнээр талбайгаа заалгаж, тариалалт хийх заавар зөвлөгөө авч хуваарилсан талбайд модоо тарьж гүйцэтгэлээ.



Зураг 13. Тариалалт хийхийн өмнө /“Айцын амны” Б хэсгийн тариалалтын талбайн баруун хэсэг/



Зураг 14. Модны нүх ухаж буй байдал



Зураг 15. Модны нүх ухсаны дараах ерөнхий байдал / Нийт 60 нүх ухаж модоо суулгасан./



Зураг 16. Мод суулгаж буй байдал / Нийт 300 ширхэг хайлаас модыг 1 нүхэнд 5 ширхгээр багцалж тарьсан/



Зураг 17. Усалгаа хийж буй байдал /Суулгаж дуусаад бүх модонд цэнэг услагаа хийсэн./



Зураг 18. Тариалалт хийж дууссаны дараах ерөнхий төлөв байдал



## 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус лабораторийн талбай болон ойр орчмын бүс үйлдвэрийн зориулалтаар олон жилийн туршид ашиглагдаж ирсэн бөгөөд одоог хүртэл хийсэн археологийн судалгаанаас үзвэл түүхийг олдвор, дурсгалт зүйл газар үгүй болно.

## 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн сорилтын шинжилгээний лаборатори ба агуулахад нь нийт 69 төрлийн 1.955 тонн химийн бодисыг хадгалж байх бөгөөд эдгээрээс шингэн бодис 10, хатуу байдалтай 59 бодис байгааг хүснэгт 6-д үзүүлэв.

**Хүснэгт 6. “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн сорилтын шинжилгээний лаборатори ба химийн бодисын агуулахад хадгалах бодисууд**

№	Химийн бодисын нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	Cas №	Хэмжээ, кг
1	Цуу хүчлийн аммони	Ammonium acetate	$\text{NH}_4[\text{CH}_3\text{COO}]$	631-61-8	6
2	Аммонны хлорид	Ammonium Chloride	$\text{NH}_4\text{Cl}$	12125-02-9	1
3	Аммонни фторт	Ammonium fluoride	$\text{NH}_4\text{F}$	12125-01-8	1
4	Аммонны молибдат	Ammonium molybdate	$(\text{NH}_4)_6\text{Mo}_7\text{O}_{24}\cdot 4\text{H}_2\text{O}$	12027-67-7	1
5	Аммоны цианит	Ammonium thiocyanate	$\text{NH}_4\text{SCN}$	1762-95-4	1
6	Аммоны сульфат	Ammonium sulfate	$(\text{NH}_4)_2\text{SO}_4$	7783-20-2	1
7	Аммон төмрийн(III) сульфат	Ammonium iron (III) sulfate decahydrate	$\text{NH}_4\text{Fe}(\text{SO}_4)_2\cdot 12\text{H}_2\text{O}$	7783-83-7	1
8	Борын хүчил	Boric acid	$\text{H}_3\text{BO}_3$	10043-35-3	2
9	Барийн хлорид	Barium Chloride dihydrate	$\text{BaCl}_2\cdot 2\text{H}_2\text{O}$	10326-27-9	2
10	Натрийн борат	Disodium tetraborate decahydrate	$\text{Na}_2\text{B}_4\text{O}_7\cdot 10\text{H}_2\text{O}$	1303-96-4	20
11	Магнийн оксид	Magnium oxide	$\text{MgO}$	8007-9-8	2
12	Төмрийн хлорид	Ferric chloride	$\text{Fe}_2\text{Cl}_3$	7705-08-0	1
13	Төмрийн оксид	Ferric oxide	$\text{Fe}_2\text{O}_3$	1309-37-1	1
14	Төмрийн сульфат	Ferrous sulfate heptahydrate	$\text{FeSO}_4\cdot 7\text{H}_2\text{O}$	7782-63-0	1
15	Устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxide	$\text{H}_2\text{O}_2$	7722-84-1	1
16	Гидроксил аммоны хлорид	Hydroxyl ammonium chloride	$\text{HONH}_3\text{Cl}$	5470-11-1	0.05
17	Төмрийн хлорид	Iron chloride tetrahydrate	$\text{FeCl}_2\cdot 4\text{H}_2\text{O}$	13478-10-9	1
18	Хар тугалганы ацетат	Lead acetate	$\text{Pb}[\text{CH}_3\text{COO}]_2\cdot 3\text{H}_2\text{O}$	301-04-2	3
19	Хар тугалганы оксид	lead oxide	$\text{PbO}$	1317-36-8	600
20	Калийн хлорид	Potassium chloride	$\text{KCl}$	7447-40-7	1
21	Калийн сульфат	Potassium pyrosulfate	$\text{K}_2\text{S}_2\text{O}_7$	7790-62-7	1
22	Калийн бихромат	Potassium dichromate	$\text{K}_2\text{Cr}_2\text{O}_7$	7778-50-9	1
23	Калийн иод	Potassium iodid	$\text{KI}$	7681-11-0	20
24	Калийн нитрат	Potassium nitrate	$\text{KNO}_3$	7757-79-1	200
25	Мөнгөний нитрат	Silver nitrate	$\text{AgNO}_3$	7761-88-8	0.4
26	Натрийн карбонат	Sodium carbonate anhydrous	$\text{Na}_2\text{CO}_3$	497-19-8	200
27	Натрийн фторид	Sodium fluoride	$\text{NaF}$	7681-49-4	1
28	Натрийн нитрат	Sodium nitrate	$\text{Na}_2\text{NO}_3$	7631-99-4	1
29	Натрийн силикат	Sodium silicate nonahydrate	$\text{Na}_2\text{SiO}_3\cdot 9\text{H}_2\text{O}$	13517-24-3	1
30	Натрийн сульфат	Sodium sulfate	$\text{Na}_2\text{SO}_4$	7757-82-6	1
31	Натрийн сульфид	Sodium sulfite anhydrous	$\text{Na}_2\text{SO}_3$	7757-83-7	1

№	Химийн бодисын нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	Cas №	Хэмжээ, кг
32	Натрийн тиосульфат	Sodium thiosulphate pentahydrate	Na <sub>2</sub> S <sub>2</sub> O <sub>3</sub> ·5H <sub>2</sub> O	10102-17-7	40
33	Цуу хүчлийн натри	Sodium acetate	Na(CH <sub>3</sub> COO)·3H <sub>2</sub> O	6131-90-4	1
34	Натрийн вольфрамит	Sodium tungstate dihydrate	Na <sub>2</sub> WO <sub>4</sub> ·2H <sub>2</sub> O	10213-10-2	1
35	Цагаан тугалганы хлорид	Stannous chloride	SnCl <sub>3</sub> ·2H <sub>2</sub> O	10025-69-1	1
36	Калийн перманганат	Potassium permanganate	KMnO <sub>4</sub>	7722-64-7	1
37	Цайрын оксид	Zinc oxide	ZnO	1314-13-2	1
38	Калийн карбонат	potassium carbonate	K <sub>2</sub> CO <sub>3</sub>	584-08-7	1
39	Цууний хүчил	Acetic acetate	CH <sub>3</sub> COOH	64-19-7	10
40	Аммиак	Ammonia solution	NH <sub>3</sub>	7664-41-7	10
41	Давсны хүчил	Hydrochloric acid	HCl	7647-01-0	220
42	Хайлуур хүчил	Hydrofluoric acid	HF	7732-18-3	50
43	Азотын хүчил	Nitric acid	HNO <sub>3</sub>	7697-37-2	200
44	Хлорын хүчил	Perchloric acid	HClO <sub>4</sub>	7601-90-3	30
45	Фосфорын хүчил	Phosphoric acid	H <sub>3</sub> PO <sub>4</sub>	7664-38-2	1
46	Калийн гидроксид	Potassium hydroxide	KOH	1310-58-3	10
47	Натрийн гидроксид	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	10
48	Хүхрийн хүчил	Sulfuric acid	H <sub>2</sub> SO <sub>4</sub>	7664-93-9	60
49	Сульфосалицилийн хүчил	Sulfosalicylic acid	C <sub>7</sub> H <sub>6</sub> O <sub>6</sub> ·S·2H <sub>2</sub> O	5965-83-3	0.1
50	Алюминон	Aluminon	C <sub>22</sub> H <sub>23</sub> N <sub>3</sub> O <sub>9</sub>	569-58-4	0.025
51	Аскорбины хүчил	Ascorbic acid	C <sub>6</sub> H <sub>8</sub> O <sub>6</sub>	50-81-7	25
52	Калцейн	Calcein	C <sub>30</sub> H <sub>21</sub> N <sub>2</sub> O <sub>13</sub> Na <sub>2</sub>	1461-15-0	0.005
53	Дифениламино сульфатат натри	Diphenylamine sulfonic acid sodium salt	C <sub>12</sub> H <sub>10</sub> NNaO <sub>3</sub> S	6152-67-6	0.1
54	Эриохром хар	Eriochrome Black T	C <sub>20</sub> H <sub>12</sub> N <sub>3</sub> NaO <sub>7</sub> S	1787-61-7	0.025
55	Флуорексон	Fluorescein	C <sub>2</sub> H <sub>12</sub> O <sub>5</sub> Na	2321-07-5	0.025
56	Метилоранж	Methyl orange	C <sub>14</sub> H <sub>14</sub> N <sub>3</sub> NaO <sub>3</sub> S	547-58-0	0.005
57	Фенолфталеин	Phenolphthalein	C <sub>20</sub> H <sub>14</sub> O <sub>4</sub>	77-09-8	0.025
58	Дарсны хүчил	Tartaric acid	C <sub>4</sub> H <sub>6</sub> O <sub>6</sub>	87-69-4	1
59	Тимол фталейн	Thymol phthalein	C <sub>28</sub> H <sub>30</sub> O <sub>4</sub>	125-20-2	0.025
60	Триэтанол ди амин	Trietanolamine	C <sub>6</sub> H <sub>15</sub> NO <sub>3</sub>	102-71-6	3
61	Тиомочевин	Thiourea	H <sub>2</sub> NCSNH <sub>2</sub>	62-56-6	1
62	Ксиленовый оранж	Xylenol orange	C <sub>31</sub> H <sub>28</sub> N <sub>2</sub> Na <sub>4</sub> O <sub>13</sub> S	3618-43-7	0.005
63	Гексамэтил тэтраамин	Hexamethylene tetramine	C <sub>6</sub> H <sub>12</sub> N <sub>4</sub>	100-97-1	0.5
64	Метол-А	Methol-A		67-56-1	2
65	Натрийн цитрат	Trisodium citrate dihydrate	Na <sub>3</sub> C <sub>6</sub> H <sub>5</sub> O <sub>7</sub>	6132-04-3	0.5
66	2,2 дипиридил	2, 2'- Bipyridyl	C <sub>10</sub> H <sub>8</sub> N <sub>2</sub>	366-18-7	0.01
67	Трилон Б стандарт давс	Trilon B	C <sub>10</sub> H <sub>16</sub> N <sub>2</sub> O <sub>8</sub> ·4Na	64-02-8	0.1
68	Иодын стандарт	Standard I2		7553-56-2	0.01
69	Цахиурын исэл	Silicon dioxide	SiO <sub>2</sub>	7631-86-9 14808-60-7	200

Шинж чанарын хувьд авч үзвэл эрдэс болон органик хүчил 11, суурь шүлт 3, хүчлийн давс 32, металлын оксид 6, органик бодис 11, стандарт уусмал 1, индикатор буюу илрүүлэгч 5 төрлийн бодисууд байна. Дээрх бүх бодисуудын химийн шинж чанар мэдэгдэж байгаа CAS № тодорхой бодисууд байгаа тул химийн бодисын хор аюулын ангиллаар доор ангилсан болно.

#### Химийн бодисын агуулах

Тус компани нь нийт 22 м<sup>2</sup> талбайтай 1 өрөө агуулахыг түрээслэн ашиглана. Тус химийн бодисын агуулахад 2020.03.26-нд Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын ажил гүйцэтгэж “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MNS 6458:2014-ийн шаардлагыг хангаж байна хэмээн дүгнэлт гаргасан байна. Уг хяналт шалгалтаар тус агуулахыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Лабораторид ашиглах химийн бодисыг хадгалах өрөө нь 22 м<sup>2</sup> талбайтай, стандартад заагдсаны дагуу тохижуулан, зориулалтын химийн бодис хадгалах аюулгүй байдлыг хангасан 4 ширхэг кабин, ацетилен, аргон хий хадгалах өрөөнд 2 ширхэг аюулгүй байдлын кабин тус тус байрлуулсан, механик агааржуулалтын систем болон хяналтын камер суурилуулсан 24 цагийн харуул хамгаалалттай.
- ✓ Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ MNS 5029:2011 стандартыг хангасан.
- ✓ Агуулахын байранд хийсэн физик хэмжилтээр гэрэлтүүлэг 250 люкс байна.
- ✓ Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээс олгосон №033/06 тоот галын аюулгүй байдлын дүгнэлттэй.
- ✓ Ажилтанд химийн бодистой харилцан ажиллах үеийн аюулгүй ажиллагааны хамгаалах хувцас, химийн бодис асгарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний иж бүрдэл зэргийг олгож, болзошгүй ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

Агуулахын ерөнхий байдлыг зураг 19-д үзүүлэв.



Зураг 19. Химийн бодисын агуулах

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны А-50/378/565 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг үндэслэн, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын”-ын дагуу химийн бодисын эрсдэлийн үнэлгээг хийлгэн 2021 онд химийн бодис ашиглах, тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан байна. Тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсаргав. Лабораторийн үйл ажиллагааны үед химийн бодистой харьцах, хадгалах, хэрэглэх дүрэм журмыг горимын дагуу хэрэгжүүлж ирсэн тул одоогийн байдлаар тус лабораторийн хэмжээнд химийн бодистой холбоотой осол, эрсдэл үүсээгүй байна.

## 7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Хог хаягдлын биелэлт

№	Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлсэн	Талбайр
1	Ахуйн хог хаягдлыг зайлуулах гэрээг түрээслүүлэгч байгууллага “Өсөх түрүү” ХХК ХУД-ийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай байгуулсан байна.	Сар бүр	425.0	ХУД-ийн ТҮК	Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаас хөрс болон усан орчин бохирдох нөхцөлийг хязгаарласан
2	Ахуйн шингэн хаягдлыг түрээслүүлэгч иргэн Ц. Бадмаанямбуу УСУГ-тай “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ” байгуулсан гэрээг хавсаргав.	-	-	УСУГазар	
3	Химийн бодисын сав баглаа боодол, лабораторийн хаягдал буюу шаазан тигель, бодисын хуванцар канистр, лабораторийн химийн урвалжуудын хаягдал, хүчлийн хуванцар сав, шилэн хаягдал, шлаг зэрэг хог хаягдлыг устгуулахаар “ТҮМЭН ЭГШИГ” ХХК-тай гэрээ байгуулан зайлуулж байна. Гэрээг хавсаргав.	-	500.0	“Түмэн Эгшиг” ХХК	Химийн бодисын хог хаягдал болон сав баглаа боодлоос үүсэх эрсдэлийг арилгасан.
<b>Дүн</b>			<b>925.0</b>		

## 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр

№	Хяналт шинжилгээ явуулсан үзүүлэлт	Шинжилгээ хийлгэсэн лаборатори	Хугацаа
<b>Агаар</b>			
1	NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , дуу чимээ	БОХЗТ лаборатори	2023.06
	Нийт тоос / TSP/		2023.09
<b>Хөрс</b>			
2	Хөрсөнд бохирдлын үзүүлэлт	“Нарт ШУҮН” лаборатори	2023.06
3	Хөрсний агрохими		2023.09
<b>Бохир ус</b>			
Лабораторийн шинжилгээнээс гарсан химийн бодисоор бохирдсон усыг саармагжуулан төв шугамд нийлүүлдэг байсан бол одоо уг саармагжуулан зайлуулж буй хаягдал бохир усыг аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах зөвшөөрөл бүхий “Түмэн эгшиг” ХХК-д гэрээгээр нийлүүлж байна.			

Хөрсөнд ерөнхий хими, хүнд элемент, эрүүл ахуйн шинжилгээг “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн Лабораторид шинжлүүлсэн (Лабораторийн задлан шинжилгээний дүнг тайланд хавсаргав).

Хүснэгт 9. Хөрсний химийн үндсэн шинж

№	Гүн, см	pH	Давс %	ЦДЧ dsm	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> %	NO <sub>3</sub> мг-100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
<b>2023 оны 9 сар</b>											
1	0-20	8.09	0.026	0.061	2.98	1.6	0.37	16	10	2.3	18

Хөрсөн дэх химийн үндсэн шинжээс дүгнэвэл дээж авсан цэгийн хувьд хүчтэй хүчиллэг урвалын орчинтой карбонаттай, ялзмагийн агууламж маш бага зэрэг, үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт суурь ( $P_2O_5 + K_2O$ )-ийн нийлбэр 20.3 мг/100гр буюу шим тэжээлийн үзүүлэлт дундаж байна. Цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй байна.

**Хүснэгт 10. Хөрсний ширхгийн хэмжээ, механик бүрэлдэхүүн**

Гүн, см	Механик ширхэгүүд, %, ширхэгийн хэмжээ, мм							Механик бүрэлдэхү үн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
<b>2023 оны 9 сар</b>								
0-20	35.8	39.7	6.2	9.3	3.9	5.1	18.3	элсэнцэр

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээр элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрстэй байна.

**Хүснэгт 11. Хөрсөн дэх хүнд металлын агууламж**

Он, сар, өдөр	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
2023.06.	Хогийн цэг	0-10	18.1	-	38.9	109.9	38.0	54.4
	Талбайн гадна	0-10	8.4	-	58.4	90.6	37.5	59.3
2023.09.	Хогийн цэг	0-20	15.8	-	235.7	80.4	35.7	25.0
<b>Хортой агууламж /MNS 5850:2019 /</b>			1000	10	500	600	400	500

Түс төслийн талбай нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд орох учир хөрсний хүнд металлын үзүүлэлтийг “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандартын дагуу хортой агууламжтай харьцууллаа. Агууламжаас давсан үзүүлэлт байхгүй буюу хэвийн хэмжээнд байна.

Энэ шинжилгээний үзүүлэлт нь 1 удаагийн хэмжилт дээжлэлтийн үр дүн бөгөөд цаашид байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээнд энэ элементийн хяналт мониторингийг үргэлжлүүлэн хийж авах арга хэмжээг шинжилгээний дүнд үндэслэн төлөвлөх шаардлагатай.

**Хүснэгт 12. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн**

Дээжийн дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
<b>2023 оны 6 сар</b>					
Дээж-1	$7.3 \cdot 10^5$	0.1	2	0.1<	1
<b>2023 оны 9 сар</b>					
Дээж-1	$8.9 \cdot 10^5$	1	1	0.1<	1

Эрүүл ахуйн үзүүлэлтүүд “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ” (MNS 3297:2019)-ийн стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй буюу хэвийн хэмжээнд байна.



Зураг 20. Хөрсний дээж авч буй байдал

Төслийн талбайд агаарын түгээмэл бохирдуулагч болох хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ ), нийт тоосонцрын хэмжилт (TSP) болон дуу чимээний хэмжилт хийв нэг цэгт нэг удаагийн хэмжилт хийв. Лабораторийн агаарын чанарын хэмжилтээр гадаад орчин болон дотоод орчны агаарын чанарын түгээмэл бохирдуулагчийн стандарт MNS4990:2015, MNS 5002:2000, MNS4585:2016 ЗДХ-ээс давсан бохирдолгүй хэмжигдсэн байна.

Хүснэгт 13. Төслийн талбайн хэмжилтийн үр дүн

№	Цэгийн дугаар	Хэмжилт хийсэн огноо	Хүхэрлэг хий мкг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мкг/м <sup>3</sup>	Нийт тоосонцор /TSP/ мкг/м <sup>3</sup>	Дуу Чимээ /ДБА/
1	Лабораторийн хашаан дотор	VI/15 10:05	0.008	0.023	0.060	36
2	Лабораторийн хашаан дотор	IX/27 10:05	0.013	0.014	0.060	30
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016 (20 минутын хэмжилт)</b>			<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>	<b>60</b>
3	Лаборатори дотор	IX/27 10:25	0.032	0.023	0.035	50
Хөдөлмөрийн аюулгүй байдал.эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015			2	2	2	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000						<b>85</b>

Эх сурвалж: Байгаль Орчин Хэмжилзүйн Төв Лабораторийн шинжилгээний дүнгээр



Зураг 21. Агаарын хэмжилт хийж буй байдал

## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК-ийн удирдлагын зүгээс дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч
1	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байсан.	2023 он	0.0	-
2	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх			
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгасан.	2023 он	500.0	-
4	Ажиллагсдыг ажил эхлэхийн өмнө болон ажил дуусах үед эрүүл мэндийг үзлэгт хамруулсан	2023 он	0.0	Оффис дээр
	<b>Дүн</b>		<b>500.0</b>	




Зураг 22. Агуулах дахь хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн самбар





Зураг 23. Галын хор ба эмийн сан



Зураг 24. Ажил эхлэхийн өмнө болон ажил дуусах үед хийгддэг эрүүл мэндийг үзлэг



Зураг 25. Галын сургалт



Зураг 26. Анхны тусламж үзүүлэх сургалт



## НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд үйлчлэх төв байр, Чингисийн өргөн чөлөө,  
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042  
Утас: 7777 1965

Цахим шуудан: [info@khanuul.mn](mailto:info@khanuul.mn)  
Цахим хуудас: [www.khanuul.mn](http://www.khanuul.mn)

2023.10.31 № 03/1787  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

「 НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ 」

“Ар Си Инспекшн Азиа Ассейрс” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Ногоон хот - Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Айцын аманд 300 ширхэг хайлаас тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг хийсэн болохыг тодорхойлов.



# “НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/09-29/1

Захиалагч: “Эх монголын байгаль” ХХК

Дээж авсан цэг: “Ар Си Инфекшн Азия ассайрс” ХХК

Сорьц авсан огноо: 2023 оны 09 сар 26 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 09 сарын 29

Харилцах утас:

## 1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca <sup>+2</sup>	Mg <sup>-2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 2											
1	0-20	8.09	0.026	0.061	2.98	1.6	0.37	16	10	2.3	18

## 1. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 2								
1	0-20	35.8	39.7	6.2	9.3	3.9	5.1	18.3

## 2. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. 1ГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 1	8.9*10 <sup>5</sup>	1	1	0.1<	1

## 3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1	0-20	35.7	235.7	0.0	80.4	25.0	15.8
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019</b>							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 3297:2019, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ :

Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ  
Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043. Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)




СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-281  
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Ар Си Инспекшн Азиа Ассайрс” ХХК  
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг агаарын хэсэг  
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ  
Сорьц авсан огноо : 2023.09.27  
Сорьцын тодорхойлолт : ХУД 3-р хороо  
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021  
MNS 5002:2000, CA3 A07-2016  
Шинжилсэн огноо : 2023.09.29  
Хуудасны тоо : 1/1  
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м <sup>3</sup>			
1	Лабораторийн гадна	IX/27	10:05	0.013	0.014	0.060	30	
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60	
2	2 давхарт лаборатори дотор	IX/27	10:25	0.032	0.023	0.035	50	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015				2	2	2	-	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000								85

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:  
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



# “НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836  
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/06-19/2

Захиалагч: “Эх монголын байгаль” ХХК  
Дээж авсан цэг: RC inspection asia assayers ХХК  
Сорьц авсан огноо: 2023 оны 06 сар 15 өдөр  
Шинжилгээ хийсэн огноо: 06 сарын 19  
Харилцах утасны дугаар:

## 1. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. ИГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо MNS6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Хогийн цэг талбай дотор						
1	Дээж 1	7.3*10 <sup>5</sup>	0.1	2	0.1<	1

## 2. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1 хогийн цэг, талбайн дотор	0-10	38.0	38.9	0.0	109.9	54.4	18.1
Дээж 2 талбайн гадна	0-10	37.5	58.4	0.0	90.6	59.3	8.4
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019</b>							
<b>Элсэрхэг хөрс</b>		<b>60</b>	<b>50</b>	<b>1</b>	<b>100</b>	<b>60</b>	<b>60</b>
<b>Шавранцар хөрс</b>		<b>100</b>	<b>70</b>	<b>1.5</b>	<b>150</b>	<b>80</b>	<b>100</b>
<b>Шаварлаг хөрс</b>		<b>150</b>	<b>100</b>	<b>3</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>150</b>

\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 3297:2019, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Т.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУУН КОНСАЛТИНГ ХХК



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2023/A-152
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Эх монголын байгаль" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.06.15
Сорьцын тодорхойлолт	: ХУД, 3-р хороо, "Ар Си Инспекшн Азиа Ассайрс" ХХК Сорилт шинжилгээний лаборатори
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021, CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2023.06.16
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м <sup>3</sup>			
1	Лабораторийн хашаан дотроос	VI/15	10:05	0.008	0.023	0.060	36	
<b>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)</b>				<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>	<b>60</b>	

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:  
инженер:




Д.Түмэндэлгэр

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй


БАТЛАВ:

“ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
АССАЙРС”

  
Г.ЧИНЗОРИГ  
ТТГ1045-5031923

БАТЛАВ:

“АР СИ ИНСПЕКШН АЗИА  
АССАЙРС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
М.ГАНЧИМЭГ

**ХИМИЙН БОДИСЫН ХАЯГДАЛ САВ БООДОЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

№23/01

2023 оны 05-р сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

Нэг талаас Монгол улс, Улаанбаатар-17011, Баянзүрх дүүрэг, 14-р хороо Намянжү-ын гудамж 44 байр, 205 тоотод байрлах “ТҮМЭН ЭГШИГ” ХХК (улсын бүртгэлийн дугаар: 9011053065, регистрийн дугаар: 5031923)-ийг төлөөлж менежер Б.Одбаяр /цаашид “Хүлээн авагч” гэх/, Нөгөө тал Монгол Улс, Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж 100/1 байр 3,4-р давхар (регистрийн дугаар: 5723612)-ийг төлөөлж Хүний нөөцийн менежер Ц.Дулмаа /цаашид “Шилжүүлэгч” гэх/ нар Шилжүүлэгчийн үйл ажиллагааны явцад гарсан химийн бодисуудын үлдэгдэл, суларсан хуванцар савнууд, шаазан тигелийг “ТҮМЭН ЭГШИГ” ХХК -ийн химийн бодисын хаягдлыг хадгалах байгууламжинд шилжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцөлөөр байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Гэрээ байгуулагч талууд нь 2017 онд шинэчлэн батлагдсан “ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ” Монгол улсын хууль, холбогдох дүрэм, журмыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулсан ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.2. Шилжүүлэгчийн зүгээс Хүлээн авагчид энэхүү гэрээний хугацаанд химийн бодисын суларсан хуванцар, шил савнууд шаазан тигельнүүд химийн бодисын саармагжуулсан үлдэгдэл (цаашид “хог хаягдал” гэх) шилжүүлснээр Хүлээн авагч нь химийн бодисын хаягдлыг аюулгүй байгууламжид хадгалж, цаашид ахуйн эргэлтэн оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

**ХОЁР. ХҮЛЭЭН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1 Хүлээн авагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль тогтоомж, тэр дундаа Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар баталсан “ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 2.2 Хүлээн авагч нь химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахтай холбоотой холбогдох эрх байгууллагын зөвшөөрөл авсан байна.
- 2.3 Хүн ам оршин суугаа газраас 500-аас доошгүй метрийн зайд, үер усанд автахааргүй байрлалтай, галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын



- үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цемент болон плит), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай агуулахад хадгална.
- 2.4. Химийн бодисын хаягдлыг агуулахад байршуулахаар Шилжүүлэгч талаас хүлээн авснаар тухайн хаягдлын хувьд бүхий л хариуцлагыг хүлээн авах үүрэгтэй.
- 2.5 Аюултай хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд албан бичгээр мэдэгдэж, аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ. Аюултай хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд албан бичгээр мэдэгдэж, аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ. Бүртгүүлсэн бүртгэлийн I хувийг шилжүүлэгч талд хүлээлгэн өгнө.
- 2.6 Устгасан тухай протоколыг шилжүүлэгч талд хүлээлгэн өгнө.
- 2.7 Аюултай хаягдал тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн, зориулалтын тээврийн хэрэгслээр хаягдлыг тээвэрлэнэ.
- 2.8 Химийн бодисын хор, аюулын талаархи лавлах мэдээлэл, тэдгээрийг тээвэрлэх болон хадгалах явцад гарч болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сургалтыг зохион байгуулна.
- 2.9 Хүлээн авагч тал нь химийн бодисын хаягдлыг тээвэрлэх хэрэгсэлд ачих, өргөх болон түүн дээр ажиллах, ачааг буулгах ажлыг бүрэн хариуцна.
- 2.10 Химийн бодистой харьцаж ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангана.
- 2.11 Шилжүүлэн авсан химийн бодисын хаягдлаас дээж авч түүнд анхан шатны шинжилгээ хийнэ.
- 2.12 Хүлээн авагчийн буруутай үйл ажиллагаанаас болж гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хүлээн авагч хохирлыг бүрэн хариуцаж төлж барагдуулах үүрэгтэй.

### **ГУРАВ. ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар баталсан **“ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ”**-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.2. Хадгалах хаягдлыг сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой бэлтгэнэ.
- 3.3. Үйлдвэрлэгчээс боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
- 3.4. Болзошгүй аюул, ослын үед ашиглах зориулалтын, бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцаж ажиллагсдыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангасан байна.
- 3.5. Хүлээлгэн өгөх химийн бодисын хаягдал, сав баглаа боодлыг жагсаалтын дагуу хүлээлгэн өгнө.

## ДӨРӨВ. ТӨЛБӨР, ТООЦОО

- 4.1. Шилжүүлэгчийн хавсралтанд заагдсан төлбөрийн дагуу химийн бодисын хаягдлыг хадгалахаар харилцан тохиролцов. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад зардал багтсан болно.
- 4.2. Энэхүү гэрээний дагуу Шилжүүлэгчээс Хүлээн авагчид төлөх төлбөрийг химийн хаягдлыг ачиж авч явсан өдөр нь ХХБ банкны 499085408 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээнд заасан төлбөрийг хуваарьт хугацаанаас хожимдуулсан тохиолдолд хоногийн 0,1 хувийн алданги тооцно.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 5.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг сунгах, эсвэл цуцлах саналаа албан бичгээр илэрхийлнэ.
- 5.3. Шилжүүлэгч талаас урьдчилж гаргасан хүсэлт, захиалгын дагуу химийн бодисын сав боодлыг ачиж тээвэрлэх хугацааг тогтоож гүйцэтгэнэ.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1. Хүлээн авагч тал нь энэхүү гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад зохих ёсоор гүйцэтгээгүй, эсвэл үүргийг зөрчсөн, аюулгүй байдлыг хангаагүйгээс Шилжүүлэгч тал, түүний ажилтан, гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд Талууд энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарсан бүх маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.2. Маргааныг хэлэлцээрээр шийдвэрлэж чадахгүй нөхцөлд хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Талуудын хүсэл, зоригийн гадуур, урьдчилан мэдэж арилгах боломжгүй дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт, хориг, газар хөдлөлт, усны үер, гал түймэр, бусад байгалийн аюулт үзэгдэл зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээг биелүүлэх боломжгүй болсон бол гэрээний оролцогчид харилцан хариуцлага хүлээхгүй.

## НАЙМ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- 8.1. Шилжүүлэгч нь Хүлээн авагчийг ажил үүргээ эхлэхийн өмнө гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч Байгаль орчны болон Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг танилцуулна.
- 8.2. Хүлээн авагч нь өөрийн ажиллагсдын аюулгүй байдлыг хариуцах хүнийг томилох, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, багаж, тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагаа, учирч болох эрсдлүүд, тэдгээрээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 8.3. Хүлээн авагч нь гэрээт ажил үүргийг гүйцэтгэх хугацааны туршид Шилжүүлэгчийн аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй байдал, Байгаль орчны хяналтын дүрэм журмыг баримтлан ажиллах бөгөөд түүнтэй холбогдон гарах, бүхий л асуудлыг өөрөө бүрэн хариуцна.

- 8.4. Хүлээн авагч нь тухайн ажилд ашиглагдаж байгаа материалын хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцан ажиллах бөгөөд тухайн ажлаас гарсан хаягдлыг хууль, журмын дагуу устгах, хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэж буй эсэхээ хянаж ажиллана.
- 8.5. Хүлээн авагч нь хэрэв аюултай бодис хэрэглэж байгаа бол урьдчилан эрх бүхий байгууллагаас хэрэглэх зөвшөөрөл авсан байх, аюултай бодис асгарч гоожихоос хамгаалах төхөөрөмжтэй байх шаардлагатай.
- 8.6. Тусгай зөвшөөрөлтэй ажиллах ажил үүрэг гүйцэтгүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас авсан зөвшөөрлийн баталгаажсан бичиг баримтыг гэрээнд хавсаргаж оруулна.
- 8.7. Хүлээн авагч нь үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах бөгөөд гарсан ослын талаар Шилжүүлэгч талд болон мэргэжлийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 8.8. Хэрэв тухайн гүйцэтгэж буй ажил нь Шилжүүлэгч талын, эсвэл Хүлээн авагч талын ажиллагсдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах нөхцөл үүссэн бол Шилжүүлэгч тал ажлыг зогсоох, гэрээг цуцлах эрхтэй.

### ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Гэрээг дагалдах хавсралтын хамт 3 хувь үйлдэн талууд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.




